Мэргэжлийн үнэ цэнэ, мэргэжилдээ дурлахуй

А.Энхтуул[1], Т.Эрдэнэчимэг[1], Б.Чимэдмаа[1], М.Наранцэцэг[1]

[1]Мэс Заслын Нэгдүгээр Тасаг, УХТЭ

Үндэслэл: Дэлхийн хамгийн эрэлт хэрэгцээтэй 100 мэргэжлийн эхний тавд сувилагч мэргэжил багтаж байна. АНУ-ын хөдөлмөрийн статистикийн товчооноос тус улсын ажиллах хүчний тоо 2018-2028 оны хооронд хэрхэн өөрчлөгдөж болох урьдчилсан тооцоог саяхан гаргаж, хамгийн ирээдүйтэй 30 ажлын байрыг жагсаасан, сувилагчийн мэргэжил тэргүүлсэн бөгөөд, цалингаараа сувилагчийн мэргэжил 2028 оны байдлаар нэгт жагссан байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн судалгаанд мэргэжлээрээ ажиллахгүй байгаа 10 гаруй мянган сувилагч байна. 2019 оны "Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ сувилагч мэргэжлээ өөрчлөх болсон шалтгаан" сэдэвт судалгааны ажлаас үзэхэд мэргэжлээрээ ажиллаж байгаа сувилагч нь 3-4 жил ажиллаад мэргэжлээ сольдог байна. Монгол улсад мэргэжлийн байгууллагууд сувилагч нарын нийгэмд эзлэх байр суурийг тусгасан өргөн цар хүрээтэй судалгааг хийгээгүй байна.

Зорилго:


1. Сувилагч мэргэжлийн ажлын үнэ цэнийг сувилагч нарын дунд судлах
2. Мэргэжлээрээ ажиллах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх шалтгааныг судлах

Зорилт:


1. Сувилагч мэргэжилтнүүд ажлын байран дээр тууштай ажиллахгүй, сэтгэл хангалуун бус байгаа шалтгааныг тодруулах тандалт судалгааг хийх.

Хэрэглэгдэхүүн ба арга, аргачлал: Сувилагч нарын мэргэжилдээ сэтгэл хангалуун бус байхад нөлөөлж байгаа нийгмийн асуудлыг тодруулан, цаашид мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэн бусдад таниулан сурч боловсрон дэлхийн жишигт хүрсэн сувилагчтай болох үүднээс УХТЭ-ийн нийт 180 сувилагчаас санамсаргүй байдлаар 80 сувилагчийг сонгон асуумжийн аргаар судалгааг авч, дескриптив загвараар үр дүнг боловсруулсан.


Үр дүн: Судалгаанд оролцогчдын 25% нь 20-25 насны, 50% нь 26-34 насны, 13,6% нь 35-49 насны, 11,3% нь 50-аас дээш насны, 29,5% нь диплом, 70,4% нь бакалаврын боловсролтой.29,5% нь 0-3 жил, 43,1% нь 3-10 жил, 27,2% нь 10-с дээш жил ажилсан байна.




Диаграм 1. Асуумж-1 Сувилагч мэргэжил сонгосон шалтгаан гэсэн асуултанд хариулсан байдал-43,1% нь эмчийн анхаарч багтаж чадаагүй гэж хариулсан байна



Диаграм 2. Асуумж-2 Ажлын байранд хэр сэтгэл ханагалуун байна гэсэн асуултанд хариулсан байдал-43% нь сэтгэл дундуур байдаг гэсэн хариулт хэлсэн.




Диаграм 3. Асуумж-3 Сувилагч мэргэжил сонгосондоо сэтгэл ханагалуун бус байгаа шалтгаан гэсэн асуултанд хариулсан байдал-сэтгэл ханагалуун бус байгаа шалтгаанаа 69,8% нь ажлын ачаалал их гэж хариулсан байна.



Диаграм 4. Асуумж-4 Цаашид суралцах хүсэлтэй байгаа эсэх гэсэн асуултанд хариулсан байдал-Судалгааны дундаж хүн ам өөр мэргэжлээр суралцах хүсэлтэй байна гэж хариулсан байна.




Диаграм 5. Асуумж-5 Сувилагчийн одоо авч байгаа цалин гэсэн асуултанд хариулсан байдал-цалингийн доод хэмжээ 600000, дээд хэмжээ 800000 төгрөг байна.



Диаграм 6. Асуумж-6 Сувилагч та хэдэн төгрөгний цалин авч таны нийгмийн Асуудал шийдэгдэх вэ гэсэн асуултанд хариулсан байдал-2 сая төгрөгний цалинтай байхад сайжирна гэж 45 хүртлэх хувь хариулсан байна.



Диаграм 7. Асуумж-7 Сувилагч та өдрийн хооолондоо хэдэн минут зарцуулдаг вэ гэсэн асуултанд хариулсан байдал-46%д огт хоолны цаг гардаггүй гэж хариулсан байна.



Диаграм 8. Асуумж-8 Сувилагчийн ажлын ачаалал гэсэн асуултанд хариулсан байдал-91% нь ажлийн ачаалал их гэж хариулсан

Дүгнэлт: Сувилахуйн тусламж нь эмнэлгийн тусламж үйлчилгээний хамгийн чухал цөм хэсгүүдийн нэг юм. Сувилагч мэргэжил нь үйлчлүүлэгчтэй хамгийн ойр ажилладаг, нийгмийн эрэлт хэрэгцээт, өсөн дэвжих боломжтой мэргэжил бөгөөд судалгааны үр дүнгээс үзэхэд сувилагч мэргэжилээр ажиллахад үдийн цайны цаг ч гардаггүй байгаа нь ажлын ачаалал их, цалин нийгмийн хангамж муу, нийгэмд үзлэх байр суурь доогуур нэр хүнд доогуур байгаа учраас мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй байна гэж дүгнэлээ.

Ном зүй:

1. *Эмнэлгийн 78 жилийн ойд зориулсан 31-р эрдмийн чуулганы илтгэлийн хураангуй. 2009он*
2. *Эмнэлгийн 78 жилийн ойд зориулсан 31-р эрдмийн чуулганы илтгэлийн хураангуй. 2010 он*
3. *Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо*
4. *Олон улсын сувилагчдын өдөрт зориулсан илтгэлийн хураангуй\ 2019он*
5. *УХТЭ-ийн 37 дахь эрдмийн чуулган-2015*
6. *Сувилагч таньд сэтгүүлүүд https://doi.org/10.1111/j.1445-2197.1994.tb04557.x*
7. *www.hdc.gov.mn*

New understanding of secondary health care nurse practitioner role optimisation: the dynamic relationship between the context and work meaning

A.Enkhtuul[1], T.Erdenechimeg[1], B.Chimedmaa[1], M.Narantsetseg[1]

[1]Department of Surgery 1st,Second State Central Hospital

Abstract: Professional nursing is one of the key factor for health service. We try to evaluate values and their significance to nursing practitioners in their daily practice by questioners. In conclusion, due to some factor (salary, overload working time, social welfare), nurses unsatisfied for their profession. In total 180 nurses from Second State Central Hospitals, 80 nurses were sampled by answered the questions in randomized control group. The findings suggest an overarching link between the work context, the meaning attributed by practice nursing roles to their work and their engagement. The optimisation of their role at the patient care level appears to be influenced by elements at the organisational and health system context levels. It appears that role optimisation must include the establishment of work environments and congruent health context structures that favour the implementation and deployment of new professional roles, work engagement, effective collaboration in interprofessional teams, and opportunities to exercise agency. Further research is necessary to evaluate initiatives that endeavour to achieve these objectives.

Keywords: practice nursing roles overarching link between the work context, work